



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН  
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Энхтайваны гудамж 136, Утас: 7012 8801,  
Факс: (976) 32 06 33, И-мэйл: admin@hdc.gov.mn,  
Вэбсайт: www.hdc.gov.mn

2022.08.30. № 709

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМНЭЛГИЙН  
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР БОЛОН ХЯНАЛТ-  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдээс 2022 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 3 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ  Б.НАРАНТУЯА - 5

УХА0456 9066331

142004000365

## Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хүлээгдлийн мэдээний нэгтгэл

/2022 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар/

### 1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн 8 дугаар сарын амбулаторийн тусламж, үйлчилгээ харьцангуй хүлээгдэл багатай байна. Харин Хэрх үе судлалын кабинетэд үзлэг хийлгэхээр 17 үйлчлүүлэгч 7 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгийн тоонд орж байна. Тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд нийт 970 үйлчлүүлэгч хүлээгдэлтэй байна. Хамгийн их хүлээгдэлтэй тасгуудын мэдээллийг Хүснэгт 1-д харуулав.

**Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл**

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг	3-6 хоног	9
		7-14 хоног	23
		15-30 хоног	50
		1 сараас дээш	211
	<b>Нийт</b>		<b>293</b>
2	Нүдний тасаг	3-6 хоног	5
		7-14 хоног	23
		15-30 хоног	55
		1 сараас дээш	210
	<b>Нийт</b>		<b>293</b>
3	Бөөрний мэс заслын тасаг	3-6 хоног	10
		7-14 хоног	25
		15-30 хоног	60
	<b>Нийт</b>		<b>95</b>
4	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	15
		7-14хоног	18
		15-30 хоног	18
		1 сараас дээш	36
	<b>Нийт</b>		<b>87</b>
5	Мэс заслын тасаг	3-6 хоног	20
		7-14хоног	32
	<b>Нийт</b>		<b>52</b>

Бүдүүн шулуун гэдэсний мэс засал болон Нүдний тасагт хэвтэхээр тус бүр 293 үйлчлүүлэгч ор хүлээж байгаагийн дийлэх буюу 72% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээж байна. Бөөрний мэс заслын тасагт хэвтэхээр 95 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 60 нь 15-30 хоног, 25 нь 7-14 хоног, 10 нь 3-6 хоног ор хүлээж байна. Харин Чих, хамар, хоолойн тасагт хэвтэхээр 87 үйлчлүүлэгч хүлээж байна.

### 2. Гэмтэл согог судлалын үндсэний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 107 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба тэдний 83% буюу хамгийн олон үйлчлүүлэгч Хүүхдийн гэмтэл согогийн кабинетэд үзүүлэхээр хүлээж байна. 2022 оны 8 сарын

28-ны өдрийн байдлаар тус кабинетэд үзүүлэхээр нийт 89 үйлчлүүлэгч хүлээж байна./ Хүснэгт 2/

**Хүснэгт 2. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Хүүхдийн гэмтэл согогийн үзлэгийн кабинетын хүлээгдэл**

№	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	3 хоног	64
2	4-6 хоног	20
3	7-с дээш хоног	5
	<b>Нийт</b>	<b>89</b>

Насанд хүрэгсдийн гэмтэл согогийн кабинет, Хүзүү, нуруу, нугасны кабинет, Гар, сарвуу нөхөн сэргээх бичил мэс заслын кабинетын 2-с дээш хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо тус бүр 4-5 орчим байсан ба бусад үзлэгийн кабинетэд хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

Тус эмнэлэгт MRI оношилгоо хийлгэхээр 155, КТГ хийлгэхээр 44 үйлчлүүлэгч тус тус 2-с дээш хоног хүлээж байна. MRI шинжилгээ хийлгэхээр хүлээж байгаа үйлчлүүлэгчдийн тал хувь нь 15-с дээш хоног хүлээгдэлтэй байна. Харин КТГ шинжилгээнд хамрагдахаар хүлээж буй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 86% нь 3-6 хоногийн хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 3/

**Хүснэгт 3. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн оношилгооны хүлээгдэл**

№	Шинжилгээний төрөл	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо	Эзлэх хувь
1	MRI	3-6 хоног	27	17,4
		7-14 хоног	50	32,2
		15-с дээш хоног	78	50,4
	<b>Нийт</b>		<b>155</b>	<b>100</b>
2	КТГ	3-6 хоног	38	86
		7-14 хоног	6	14
		15-с дээш хоног	-	
	<b>Нийт</b>		<b>44</b>	<b>100</b>

Тус эмнэлгийн амбулаторийн бусад кабинет, лаборатори болон хэвтүүлэн эмчлэх үйлчилгээнд хүлээгдэл бүртгэгдээгүй байна.

**3. Хавдар судлалын үндэсний төв**

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 364 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба Эмэгтэйчүүдийн мэс заслын үзлэгийн кабинетэд үзүүлэхээр хамгийн их буюу 85 үйлчлүүлэгч 7 ба түүнээс дээш хоногоор хүлээж байна. Хамгийн ихээр хүлээгдэлтэй байгаа үзлэгийн кабинетуудыг хүснэгт 4-д харуулав.

**Хүснэгт 4. Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн хүлээгдэл**

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо		
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	-	-	85
2	Толгой, хүзүүний мэс засал	-	1	45
3	Элэг, цэс, нойр булчирхайн мэс засал	-	1	45
4	Хими	-	1	43
5	Ерөнхий мэс засал	-	3	38
6	Хөхний төв	-	-	35
7	Туяа	-	1	22
8	Гепатологи	1	4	17
9	Ангиографи	-	-	17
10	Ерөнхий хавдар судлал	-	-	12
11	Зүрх судас	-	-	4
12	Цээжний хөндийн мэс засал	-	3	1
13	Хөнгөвчлөх	-	2	
	<b>Нийт</b>	<b>1</b>	<b>16</b>	<b>364</b>

Толгой, хүзүүний мэс заслын үзлэгийн кабинет болон Элэг, цэс, нойр булчирхайн мэс заслын үзлэгийн кабинетэд тус бүрт 45, Хими эмчилгээний амбулаториор үзүүлэхээр 43, Ерөнхий мэс заслын үзлэг хийлгэхээр 38, хөхний төвд үзүүлэхээр 35 үйлчлүүлэгч тус тус 7 ба түүнээс хоногийн дээш хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 2-с дээш хоног нийт 121 үйлчлүүлэгч хүлээж байгаа ба КТГ болон эхо оношилгоо хийлгэхээр тус бүр 41, ходоод дурандуулахаар 23 үйлчлүүлэгч 7 ба түүнээс дээш хоногоор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд хамаарч байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Хими эмчилгээ хийлгэхээр 111 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа ба үүнд хавдартай үйлчлүүлэгчид 14-21 хоногийн давтамжтай товлолт хими эмчилгээ хийдэг нь хүлээгдэлтэй харагдахад нөлөөлдөг болно. Хөнгөвчлөх болон ангиографийн тасагт хэвтэхээр тус бүр 21, хөхний төвд эмчлүүлэхээр 13 үйлчлүүлэгч 7-с дээш хоног хүлээсээр байгаа нь тус эмнэлгийн хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд орж байна.

#### 4. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх болон лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй байна. Харин Гоо заслын кабинетад үзүүлэхээр 114 үйлчлүүлэгч 3 хоног, 115 үйлчлүүлэгч 4-6 хоногийн хүлээгдэлтэй байна.

- Эх, хүүхдийн Эрүүл мэндийн үндэсний төв болон Халдварт өвчин судлалын үндэсний төвүүд хүлээгдэлгүй ажиллаж байна.
- Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2, Амаржих газрууд болон Нийслэлийн эрүүл мэндийн газар зэрэг нь хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.